



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/54/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: <a href="mailto:Bat-Undraa@audit.gov.mn">Bat-Undraa@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч : Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: <a href="mailto:daqvasurenb@audit.gov.mn">daqvasurenb@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Б.Мөнхнасан Утас:90066888 Цахим хаяг: <a href="mailto:munkhnasanb@audit.gov.mn">munkhnasanb@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал .....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улаанбаатар, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

2022.09.25, № 1302 / 394,  
төмөр \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Д.ТҮВШИНЖАРГАЛ-д

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Audit(D)A4-тоот/2022

010025392

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,663,849</u></b>	<b><u>2,663,849</u></b>
	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	63849	63849
	Кассанд байгаа бэлэн мөнгө	63849	63849
	Төгрөг	63849	63849
35410	Авлага	2,600,000	2,600,000
35420	Бусад авлага	2,600,000	2,600,000
	Байгууллагаас авах авлага	2,600,000	2,600,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,663,849</u></b>	<b><u>2,663,849</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,663,849</u></b>	<b><u>2,663,849</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,663,849	2,663,849
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,663,849	2,663,849
51210	Өмнөх үеийн үр дүн	2,663,849	2,663,849
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	2,663,849	2,663,849

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,656,301.00</b>	<b>946,961,043,00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>19,857,143</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>19,857,143</b>
120004	Бусад орлого		<b>19,857,143</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,656,301,00</b>	<b>937,103,90</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,503,879,000	501,433,100
131103	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	152,422,000	425,670,800
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>418,197,693</b>	<b>758,481,043</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>418,197,693</b>	<b>758,481,043</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	372,083,093	647,181,000
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	15,397,200	15,397,200
210101	Гэрээт ажлын хөлс	15,397,200	15,397,200
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,078,600	2,078,600
210201	Тэтгэврийн даатгал	1,462,700	1,462,700
210202	Тэтгэмжийн даатгал	154,000	154,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	123,200	123,200
210204	Ажилгүйдлийн даатгал	30,800	30,800

210205	Эрүүл мэндийн даатгал	307,900	307,900
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	59,351,400	59,351,400
210301	Гэрэл, цахилгаан	3,660,200	3,660,200
210302	Түлш, халаалт	51,840,000	52,160,900
210303	Цэвэр, бохир ус	3,851,200	3,530,300
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	125,477,093	127,326,200
210503	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	125,477,093	127,326,200
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	169,778,800	443,027,600
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	169,778,800	443,027,600
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	32,344,600	111,300,043
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,973,000	22,449,300
213207	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,973,000	22,449,300
<b>2133</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох, татаас санхүүжилт</b>	21,361,600	88,850,743
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,361,600	88,850,743
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,238,103,307</u></b>	<b><u>188,480,000</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,238,103,307</u></b>	<b><u>188,480,000</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,663,849,00	2,663,849,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			2,663,849,00	2,663,849,00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,663,849,00	2,663,849,00
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			2,663,849,00	2,663,849,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			2,663,849,00	2,663,849,00
D09	2021 оны 6-р сарын 30-нээрх үлдэгдэл			2,663,849,00	2,663,849,00

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,656,301.00</b>	<b>946,961,043,00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>19,857,143</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>19,857,143</b>
120004	Бусад орлого		<b>19,857,143</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,656,301,00</b>	<b>937,103,90</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,503,879,000	501,433,100
131103	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	152,422,000	425,670,800
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>418,197,693</b>	<b>758,481,043</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>418,197,693</b>	<b>758,481,043</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	372,083,093	647,181,000
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	15,397,200	15,397,200
210101	Гэрээт ажлын хөлс	15,397,200	15,397,200
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,078,600	2,078,600
210201	Тэтгэврийн даатгал	1,462,700	1,462,700
210202	Тэтгэмжийн даатгал	154,000	154,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	123,200	123,200
210204	Ажилгүйдлийн даатгал	30,800	30,800
210205	Эрүүл мэндийн даатгал	307,900	307,900
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	59,351,400	59,351,400
210301	Гэрэл, цахилгаан	3,660,200	3,660,200
210302	Түлш, халаалт	51,840,000	52,160,900
210303	Цэвэр, бохир ус	3,851,200	3,530,300
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	125,477,093	127,326,200
210503	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	125,477,093	127,326,200
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	169,778,800	443,027,600
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	169,778,800	443,027,600
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	32,344,600	111,300,043
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,973,000	22,449,300
213207	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,973,000	22,449,300
<b>2133</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох, татаас санхүүжилт</b>	21,361,600	88,850,743
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,361,600	88,850,743
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,238,103,307</u></b>	<b><u>188,480,000</u></b>

5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,238,103,307</u></b>	<b><u>188,480,000</u></b>
---	--------------------------------	-----------------------------	---------------------------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	858,110,300	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	669,630,300	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	647,181,000	
210105	Гэрээт ажлын хөлс	15,397,200	15,397,200
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,078,600	2,078,600
210201	Тэтгэврийн даатгал	1,462,700	1,462,700
210202	Тэтгэмжийн даатгал	154,000	154,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	123,200	123,200
210204	Ажилгүйдлийн даатгал	30,800	30,800
210205	Эрүүл мэндийн даатгал	307,900	307,900
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	59,351,400	59,351,400
210301	Гэрэл, цахилгаан	3,660,200	3,660,200
210302	Түлш, халаалт	51,840,000	52,160,900
210303	Цэвэр, бохир ус	3,851,200	3,530,300
<b>2104</b>	<b>Нормативт зардал</b>	125,477,093	127,326,200
210401	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	125,477,093	127,326,200
210402	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	169,778,800	443,027,600
210403	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	169,778,800	443,027,600
210405	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	32,344,600	111,300,043
210406	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,973,000	22,449,300
<b>2105</b>	<b>Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал</b>	10,973,000	22,449,300
210503	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох, татаас санхүүжилт</b>	21,361,600	88,850,743
<b>2106</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	21,361,600	88,850,743
210601	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,238,103,307</u></b>	<b><u>188,480,000</u></b>
210604	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,238,103,307</u></b>	<b><u>188,480,000</u></b>

## **2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан-оруулах**

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Б.Мөнхнасан гүйцэтгэж, аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Засаг дарга нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай байна гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 136,631,200.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,366,312.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 888,102.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,600,000	2,600,000	0
Бараа материал	0	0	0
Үндсэн хөрөнгө	0	0	4,305.9
<b>Нийт хөрөнгө</b>	0	0	0
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,663,849	2,663,849	0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	2,663,849	2,663,849	0

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 418,197,693 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 758,481,043 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 946,961,043 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 501,433,100 мянган төгрөгийг зарцуулж, 88,850,743 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар 19,857,143 мянган төгрөг олгож зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн, Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цагалбар, болон НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ямар нэгэн зөвлөмж өгөгдөөгүй.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тус байгууллагын төсвийн зардлын зарцуулалтыг хянахад албан томилолтоор ажилласан албан хаагчид албан томилолтын хуудсанд очсон, ирсэн хугацааг бичүүлээгүй, очсон газрын баталгаажуулсан хугацаагаар бус томилсон хоногоор томилолт тооцож олгосон дутагдал илэрснийг залруулах шаардлагатай байна.

#### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар залруулсан, акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй болно.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар залруулга хийгдээгүй болно.